



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/306

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын багц-4, 6-н ажлуудын гүйцэтгэл, чанарт хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Цогтбаяр -Жаргалант сумын дэд бүтэц хариуцсан орлогч дарга

Б.Жамбалдорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Нарийн бичгийн


дарга Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.

2.Жаргалант сумын багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын багц-4, 6-н ажлуудыг зураг, төсөв, стандартын дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/- д даалгасугай.

3. Дээрх ажлуудад хяналт шалгалт хийхтэй холбогдон гарах зардлыг тухайн тус бүрийн ажлуудын захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН